БАТЛАВ.
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ОЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ОЮУНСАНАА

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ, ОЙЖУУЛАХ АЖИЛ

2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр Улаанбаатар хот

№ **Ажлын нэр** Ойг нөхөн сэргээх, ойжуулах ажил

1 Багцын мэдээлэл

Багц дугаар	Багцын нэр	Байршил	Талбайн хэмжээ /га/
БАГЦ №1	Дорнод аймгийн Баян-Уул сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	Цагаан дэвийн рашаан	20
БАГЦ №2	Завхан аймгийн Түдэвтэй сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	Шар нуруу баг Ар цагаан чулуу	20
БАГЦ №3	Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	Баян зураа	20
БАГЦ №4	Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	Далхын ам	20
БАГЦ №5	Төв аймгийн Батсүмбэр сумын доройтсон ойн 28 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	Өлгийн ам Хомбоо	28
БАГЦ №6	Улаанбаатар хотын ногоон бүсийн доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	БЗД-ийн 20-р хороо Бага Хуандий ам	20

2 Хугацаа Шалгарч гэрээ байгуулснаас хойш 2024 оны 12 дугаар сарын 31 хүртэл.

3 Ажлын Дараах ажилбаруудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

хамрах хүрээ:

1. Бэлтгэл ажил
2. Ойжуулалт хийх
3. Ойжуулсан талбайг хүлээлгэн өгөх
4. Зөрчил гологдол арилгах
5. Тайлан боловсруулах
6. Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх
7. Дараа жилийн арчилгаа хамгаалалт

1. Бэлтгэл ажил:

- Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдыг дадлагажуулах;
- Ойжуулалтын ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн ажилд гарахад бэлэн болгох;
- Ойжуулалтын ажлын технологийн карт, дараалал боловсруулан ажилчдад танилцуулах, мөрдөх /технологийн дараллын загварыг хавсаргав/
- Ойжуулах талбайг сонгох тэмдэгжүүлэх /Талбай сонгох ажлыг Ойн газрын холбогдох мэргэжилтнүүд, аймаг, дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумын болон сум дундын ойн ангийн инженер техникийн ажилчидтай зөвшилцөн сонгох/;
- Ойжуулах талбайг хашиж мал бэлчихээс хамгаалах;
- Ойжуулах талбайг цэвэрлэх /унанги, гишүү цэвэрлэх/;
- Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгөх;
- Ойжуулалтын ажлыг гүйцэтгэх улирлын болон түр ажилчдад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх;
- Тарьцыг бойжуулах талбайгаас ухаж авах, тээвэрлэхэд бэлдэх;
- Тээвэрлэх, суулгах үед үндэсний систем хатахаас хамгаалах арга хэмжээ авах;
- Тарьц хадгалах нүх шуудуу бэлдэх
- Ойр орчмын иргэдэд мал бэлчээхийг хориглох талаар танилцуулга, уулзалт зохион байгуулах

2. Ойжуулалт хийх.

- “Мод сөөгний тарьц. Техникийн шаардлага” MNS 6140:2010 стандартад нийцсэн нарсны тарьц ойжуулалтын ажилд хэрэглэх
- Ойжуулахаар сонгосон талбайд зонхилон ургаж буй шилмүүст модны тарьцаар ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

4 Гүйцэтгэх ажлын агуулга, үе шатууд

- Ойжуулалтын ажлыг газар гэссэний дараа 05-р сарын 15-аас 06-р сарын 01 хүртэл хийх бөгөөд, шаардлагатай тохиолдолд нөхөн тарилтыг 10-р сарын 01-аас 10-р сарын 25-ны дотор тус тус хийх
- Хөрсийг 0.4 х 0.4 метр хэмжээтэй жижиг талбайгаар гараар боловсруулна. Эгнээ хооронд 4 метр байхаар утас татаж жижиг талбайнуудыг 4 х 1 метрийн зайтайгаар жигд байрлуулан хөрсний өнгөн хэсгийг 5-10 см гүнтэйгээр өвөөлжин жоотуу болон бусад гар багажуудаар хуулж аван газрын доод талд эргүүлэн дээш харуулж тавина /Схем 1/.
- Ойжуулалтын шигүүрэл: мод хоорондоо 1 метр, эгнээ хооронд 4 метр байхаар тооцон 1 га талбайд 2500 ширхэг бортоготой тарьц байхаар тооцож тарилт хийх /Схем 2/

- Хөрсний чийг тохиромжтой хувиас доогуур тохиолдолд услагаа хийх
- Хөрсийг 4-5 см-ийн гүнд зөөллөж, хөл газрын ургамлыг устгахын хамт усалгааны дараа хөрсний чийгийг алдагдуулахгүйн тулд шороогоор дарж тарьц суулгац суулгасан нүхийг өргөтгөх
- Хөрсний өнгөн хэсгийг эрдсийн давхарга хүртэлх бүх шатах материалыг бүрэн зайлуулж хагалан харлуулсан зурвас байгуулах, зурвасын өргөн дунджаар 1,5-3 м, ойн захаас 10-20 м зайтай, зонхилох салхины чиглэлийн хөндлөн байх зэрэг нөхцөлийг тооцох

3. Ойжуулсан талбайг хүлээлгэн өгөх.

Ойжуулсан талбайг Ойн газраас томилогдсон ажлын хэсэг, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт тус тус актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна. Ойжуулалтын ажлын явцын хяналтыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Ойн газраас томилогдсон ажлын хэсэг, төслийн менежер, орон нутгаас томилогдсон ажлын хэсэг тус тус хийж гүйцэтгэнэ. Ойжуулсан талбайг тухай аймаг, суманд акт үйлдэн хүлээлгэн өгнө. Актыг 5 хувь үйлдэх бөгөөд Ойн газарт эх хувиар нь ирүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон ажлын хэсгийн гаргасан актыг үндэслэн тарьсан тарьц, суулгацын амьдралт 75.0 хувиас дээш байвал уг ажлын гүйцэтгэлийг хангалттай гэж үзэн хүлээн авна. Амьдралтын хувийг тогтоохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29 өдрийн А-96/71 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх" журмын дагуу жишиг талбай байгуулан тооллого явуулна.

Ойжуулсан талбай /га/	Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь	Нэгж жишиг талбайн хэмжээ /м^2/
1-5	5	200
6-10	4	400
11-20	3	400
21-ээс дээш	2	400

Ойжуулалтын ажлыг хүлээн авахдаа гэрээний ерөнхий ба тусгай нөхцөлийн дагуу зөрчил, гологдлыг арилгасны дараа "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх" журмаар батлагдсан актын дагуу хүлээн авна.

Ажлыг гүйцэтгэх хугацаанд тухайн аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги болон сум орон нутагтай хамтран ажиллана.

4. Зөрчил, гологдол арилгах.

- Тарьсан тарьц нь 50-74,9 хувийн амьдралтай ургасан бол

гүйцэтгэгч өөрийн зардлаар 90 хувь хүртэл нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгнө.

- Тарьсан тарьц нь 25-49,9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон норматив зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна.
- Тарьсан тарьц нь 24,9 хүртэл хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ойжуулалтын ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлнэ.

5. Тайлан боловсруулах.

Ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайланг захиалагчид 2 хувь ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

а/ “Ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайлан”;

б/ 1:50000-ны масштабтай Ойжуулалтын ажил явуулсан талбайн зураг;

в/ “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт.

а. “Ойжуулалтын ажил гүйцэтгэсэн тайлан”-д:

Ойжуулалтын ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ойжуулалтын ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага хангасан байдал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг багтаана. Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, ойжуулсан талбайн ерөнхий байдлын зургийг тайланд хавсаргана.

б. “Ойжуулалтын ажил явуулсан талбайн зураг”-т: Хэсэглэл, ялгарлын хил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр , газар зүйн байрлалын солбицлын торлол, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.

в. “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт тайланд хавсаргана.

Тайланг захиалагчийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно.

Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтийн тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагийг хэрэглэнэ.

Ойжуулалтын ажлын тайлан болон зургийн shp.файлуудыг цахим

		хэлбэрээр /CD, DVD/ 1 хувь ирүүлнэ. **6. Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх** Ойжуулалтын ажлын тайланг Ойн газарт хоёр хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарьт тусгасан болно. Тайланг нээлттэйгээр хэлэлцүүлнэ. **7. Дараа жилийн арчилгаа, хамгаалалт** “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу ойжуулсан талбайгаа 3 жилийн хугацаанд арчлан хамгаалж ургуулах бөгөөд энэ үзүүлэлтийг дараагийн ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад нэг шалгуур үзүүлэлт болгоно. Шаардлагатай үед нөхөн тарилт хийх, хашаа хамгаалалтыг сэргээх, усалгаа хийх, түймэр хөнөөлт шавжаас хамгаалах арга хэмжээ зохион байгуулах, хөл газрын ургамалтай тэмцэх, хөрс сийрүүлэх зэрэг арга хэмжээг 3 жилийн хугацааны турш хийж гүйцэтгэнэ.
5	**Тавигдах шаардлага**	Дараах шаардлага тавигдана. Үүнд: -Ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээтэй байх /мод үржүүлэх, ойжуулах ойг нөхөн сэргээх зөвшөөрөл/ -Ерөнхий инженер нь Ойн инженер чиглэлээр 5 болон түүнээс дээш жил ажилласан, инженер нь Ойн инженер чиглэлээр 3 болон түүнээс дээш жил ажилласан, ойжуулагч нь тухайн чиглэлээр сургалтад хамрагдаж төгссөн бөгөөд 1 болон түүнээс жил ажилласан ажлын туршлагатай байх --Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин, багаж хэрэгсэлтэй байх -Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр хийсэн ажлын туршлагатай байх (2020, 2021, 2022 он тус бүрд хийсэн ажлын гэрээ, акт)
6	**Үр дүнг тайлагнах**	Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг үндэслэн гэрээг сунгах, цуцлах эрхтэй

ОЙЖУУЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ, АРЧИЛГААНЫ АЖЛЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД
(MNS, ISO9001:2015, UCS)

Доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажлыг гэрээгээр гүйцэтгэх байгууллага нь ойжуулалт, тарьц суулгацын стандартуудыг мөрдөж ажиллана.

№	**Стандартын нэр**	**Стандартын тэмдэглэгээ**
1	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа	MNS 4969:2000
2	Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага	MNS 6139:2010
3	Мод сөөгний тарьц. Техникийн шаардлага	MNS 6140:2010
4	Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага	MNS 6141:2010
5	Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах, Ерөнхий шаардлага	MNS 2418:2011
6	Мод үржүүлгийн газар бордоо хэрэглэх	MNS 6252:2011
7	Мод сөөгний үрийг тарихад бэлтгэх, Ерөнхий шаардлага	MNS 6253-1:2011
8	Мод сөөгний үр тарих Ерөнхий шаардлага	MNS 6253-2:2011
9	Мод сөөгний үр тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага	MNS 6253:2011
10	Мод сөөгний суулгацыг бойжуулах, Ерөнхий шаардлага	MNS 6254:2011
11	Сөөгний суулгац. Ерөнхий шаардлага	MNS 6255:2011
12	Сөөгөнцөрийн суулгац. Ерөнхий шаардлага	MNS 6256:2011
13	Улиасны суулгац. Ерөнхий шаардлага	MNS 6257:2011
14	Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага	MNS 6258-1:2011
15	Мод сөөгний суулгац арчлах	MNS 6258-2:2011
16	Улиасны модожсон мөчрийн тайраадас. Ерөнхий шаардлага	MNS 1796:2011
17	Бордоо. Доломитын бордоо Техникийн шаардлага	MNS 6662:2017
18	Сөөгний суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах Техникийн шаардлага	MNS 6773:2019
19	Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах	MNS 6774:2019
20	Голтборын төрлийн ургамлыг тарих, арчлах. Техникийн шаардлага	MNS 6863: 2020
21	Мод үржүүлгийн газарт гоёл чимэглэлийн мод, сөөгний суулгац ургуулах Техникийн шаардлага	MNS 6864:2020
22	Навчит модны суулгац, техникийн шаардлага	MNS 6141:2020
23	Азот фосфор калийн холимог бордоо, техникийн шаардлага	MNS 5891:2008
24	Фосфорын бордоо	MNS 4305: 1996

ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ, ОЙЖУУЛАХ
АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Багц дугаар	**Багцын нэр**	**Байршил**	**Талбайн хэмжээ /га/**	**Тарих модны төрөл**	**Нийт тарих модны тоо, ширхэг**
БАГЦ №1	Дорнод аймгийн Баян-Уул сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	Цагаан дэвийн рашаан	20	Бортоготой нарс	50,000
БАГЦ №2	Завхан аймгийн Түдэвтэй сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	Шар нуруу баг Ар цагаан чулуу	20	Бортоготой шинэс	50,000
БАГЦ №3	Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	Баян зураа	20	Бортоготой шинэс	50,000
БАГЦ №4	Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	Далхын ам	20	Бортоготой нарс	50,000
БАГЦ №5	Төв аймгийн Батсүмбэр сумын доройтсон ойн 28 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	Өлгийн ам Хомбоо	28	Бортоготой шинэс	70,000
БАГЦ №6	Улаанбаатар хотын ногоон бүсийн доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил	БЗД-ийн 20-р хороо Бага хуандий ам	20	Бортоготой шинэс	50,000

БАГЦ №1. Дорнод аймгийн Баян-Уул сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил гүйцэтгэх талбайн байршлын тойм зураг



БАГЦ-2. Завхан аймгийн Түдэвтэй сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил гүйцэтгэх талбайн байршлын тойм зураг



БАГЦ-3. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил гүйцэтгэх талбайн байршлын тойм зураг



БАГЦ-4. Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил гүйцэтгэх талбайн байршлын тойм зураг

БАГЦ-5. Төв аймгийн Батсүмбэр сумын доройтсон ойн 28 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил гүйцэтгэх талбайн байршлын тойм зураг

БАГЦ-6. Улаанбаатар хотын ногоон бүсийн доройтсон ойн 20 га талбайг нөхөн сэргээх, ойжуулах, арчлах ажил гүйцэтгэх талбайн байршлын тойм зураг



УЛААНБААТАР ХОТ БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 20-р ХОРОО БАГА ХУАНДЫН АМ ОЙЖУУЛАЛТЫН АЖИЛ ХИЙХ ТАЛБАЙН ЗУРАГ

Газрын нэр: Бага хуандын ам
Хэсэглэлийн дугаар: 176
Ялгаралын дугаар: 31
Талбайн хэмжээ: 20 га
Ой зохион байгуулалт: 2016 он

Ойжуулалт хийх талбайн координат:

107 14 52,6	47 54 40,2	1-2цэг	550м
107 15 17,9	47 54 44,8	2-3цэг	380м
107 15 25,1	47 54 33,4	3-4цэг	150м
107 15 19,7	47 54 30,1	4-5цэг	260м
107 15 07,8	47 54 33,5	5-6цэг	230м
107 14 57,9	47 54 31,0	6-1цэг	300м